



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/529

Булган сум

**Аймгийн баяр наадмын төсөв  
батлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 14 дүгээр хуралдааны 14/01 тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 102 жилийн ой, Булган аймаг байгуулагдсаны 85 жилийн ой, аймгийн баяр наадмын төсвийг хавсралтаар баталсугай.

2. Баяр наадмын арга хэмжээний 113,650,000 (нэг зуун арван гурван сая зургаан зуун тавин мянга) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 10,000,000 (арван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газраас 10,000,000 (арван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөрийн “Алтаргана-2024 наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх” төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг Засаг даргын тамгын газар (Д.Алтаншагай), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023 оны  
07 дугаар сарын 03-ны өдрийн А/529 дугаар  
захирамжийн хавсралт

Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 102 жилийн  
ой, Булган аймаг байгуулагдсаны 85 жилийн ойн баяр наадмын төсөв

Д/д	Зориулалт, арга хэмжээ	Ирүүлсэн санал /мян.төг/	Хянасан төсөв /мян.төг/
1	2	3	4
1	Үндэсний бөхийн барилдаан	12,761.2	9,425.2
2	Хурдан морины уралдаан	28,500.0	23,832.2
3	Үндэсний сурын харваа	7,176.9	7,176.9
4	Үндэсний шагайн харваа	5,387.6	4,596.8
5	Нийгмийн хэв журам сахиулах арга хэмжээ	13,153.2	7,465.0
6	Хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, орчны ариун цэврийн шаардлага хангуулах	2,785.4	1,109.4
7	Нийгэм, соёл, урлагийн арга хэмжээний зардал	64,500.0	40,000.0
8	Аж ахуйн зардал	35,648.0	24,187.0
9	Хэвлэл мэдээлэл, сурталчилгаа	12,587.0	8,830.0
10	Засвар, тохижилтын ажил	24,222.4	7,027.5
	<b>Дүн</b>	<b>206,721.7</b>	<b>133,650.0</b>